



**МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ**

Засгийн газрын VII байр, Энхтайваны өргөн чөлөө 51,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13340
Утас: 26 35 31, Факс: (976-11) 45 81 12,
Цахим шуудан: info@mod.gov.mn
Цахим хаяг: www.mod.gov.mn

2025 12 24 № 06/4744
танай 2025 11 05 -ны № 05/18879 -т

Тайлан хүргүүлэх тухай

Батлан хамгаалах салбарын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан (нотлох баримт: төлөвлөгөө, постер, рийл, видео шторк), Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт Батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хүрүүлж байна.

1 дүгээр хавсралт: Батлан хамгаалах яамны 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, 9 хуудастай;

2 дугаар хавсралт: Батлан хамгаалах салбараас 2025 онд авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт, 5 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Д.ГАНХУЯГ



1325113543

Батлан хамгаалах яамны 2025 оны
12 дугаар сарын 14-ны өдрийн
16/4744 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН


НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Батлан хамгаалах яам 2025 онд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгах, эрсдэлийг бууруулах, Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх, энэ чиглэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилго дэвшүүлэн ажиллалаа.

№	Ажил хэрэгсэл, үйл ажиллагаа	Хэрэгсэл, үйл ажиллагаа	Хэрэгсэл, үйл ажиллагаа	Хэрэгсэл, үйл ажиллагаа	Хэрэгсэл, үйл ажиллагаа	Хэрэгсэл, үйл ажиллагаа
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх
2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Батлан хамгаалах яамны 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, Батлан

хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, яамны харьяа аж, ахуйн нэгж, байгууллагын удирдлага, бие бүрэлдэхүүнд авлигын эсрэг нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун, соёлыг төлөвшүүлэх зорилго тавьж, нийт бие бүрэлдэхүүний авлига, ашиг сонирхлын талаарх хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, нөлөөллийн компанит ажил, арга хэмжээ зохион байгуулах, авлига, ашиг сонирхол гарч болох шалтгаан, нөхцөлийг судлан, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах 4 зорилтын хүрээнд 13 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, жилийн эцсийн байдлаар төлөвлөсөн ажил, арга хэмжээг 92,3% гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 1 ажил цаг, үеийн нөхцөл байдлаас шалтгаалж хэрэгжээгүй байна.



Мөн яамны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Зэвсэгт хүчний Жанжин штаб болон яамны харьяа 15 аж ахуйн нэгж, байгууллагад Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 1в/624 дүгээр албан бичгээр хүргүүлэн, яамны төлөвлөгөөний дагуу өөрсдийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг уялдуулан боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах талаар зөвлөмж, чиглэлийг хүргүүлэн ажиллалаа.

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3¹-т заасны дагуу Батлан хамгаалах яам 80, Үндэсний батлан хамгаалахын их сургууль 143, Цэргийн төв эмнэлэг 76, Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга 12, Алдар спорт хороо 15, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн 22, Батлан хамгаалахын төв архив 5, Монгол цэргийн музей 2, "Соёмбо" редакц 9, Батлан хамгаалахын эмгэг судлал, шүүх эмнэлэг 2, БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ, дэмжлэгийн хэлтэс 10, Батлан хамгаалахын аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ 2, "Бөртэ" ТӨААТҮГ 4, "Багабаян Энхийн төлөө цогцолбор төв" ТӨААТҮГ 2, Барилга захиалагчийн алба" ТӨААТҮГ 2, "Зэв" Улсын үйлдвэрийн газар 10, нийт 16 байгууллагын 397 офицер, ахлагч, ажилтан, албан хаагчдаас хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын 2024 оны мэдүүлгийг авч, 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн дотор цаасан суурьтай хэлбэрээр бүртгэн авч, холбогдох 3 төрлийн тайлан, мэдээг гаргаж, Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн болно.

Мөн 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Батлан хамгаалах яам болон яамны харьяа 15 аж, ахуйн нэгж, байгууллагад томилогддог 150 гаруй алба хаагчийн нийтийн албанд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т албан бичгээр хүргүүлж, хянуулан хариуг авч ажилласан байна.


Мөн Батлан хамгаалах яаманд шинээр томилогдсон 15 албан хаагчдаас 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг авч, бүртгэл хөтөлсөн.

ХОЁР. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:



Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг"-ийн маягт шинэчлэн батлагдсантай холбогдуулан Батлан хамгаалах яам, харьяа 15 байгууллагын хуулийн офицерууд, эрх бүхий албан тушаалтнуудтай хамтран Хувийн ашиг

¹ "Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй"



сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг офицер, ахлагч, ажилтан албан хаагч нийт 230 гаруй албан хаагчдад Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг хэрхэн бөглөх талаарх мэдээлэл болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаарх сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 24-

ний өдрүүдэд харьяа 5 байгууллагын байрлалд сургалт зохион байгуулж, авлигагүй албан хаагч болох соёлыг түгээх зорилгоор мэдээлэл хүргэж, уриаллаа.

Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн комиссар Ж.Мөнхжаргал “Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг” сэдвээр сургалтыг Үндэсний батлан хамгаалах их сургууль, Цэргийн төв эмнэлгийн байрлалд зохион байгуулсан бөгөөд сургалтад нийт 245 офицер, ахлагч, ажилтан албан хаагч хамрагдсан.



Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах асуудал болон авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх зорилгоор 2025 оны



02 дугаар сарын 25-ны өдөр Үндэсний батлан хамгаалах их сургуулийн 300 гаруй алба хаагчдад Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлигын эсрэг манлайлал” сэдвээр сургалтыг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, ахлах комиссар М.Жамъянчойжил орсон бол Батлан хамгаалахын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 34 алба хаагч, Батлан хамгаалахын удирдлагын академид Батлан хамгаалахын сайдын тушаалаар “Нэгтгэл, ангийн захирагчийн дамжаа”-нд хамрагдаж буй Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн 20 гаруй ангийн захирагч нарыг хамруулан “Авлига, сонирхлын зөрчлөөс сэргийлэх нь” сэдэвт сургалтыг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Ж.Мөнхжаргалаар удирдуулан зохион байгуулсан.




Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

тухай хуулийн 3 дугаар бүлэгт нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалт, 17 дугаар зүйлд заасан "Хандив авахтай холбогдсон хязгаарлалт"-ыг зөрчихгүй байх талаарх мэдээллийг АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар Ж.Мөнхжаргалтай хамтран Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Бөртэ ТӨААТҮГ, Барилга захиалагчийн алба ТӨААТҮГ-ын удирдлагын түвшинд сургалт хэлбэрээр 3 удаа зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс гаргаж байгаа гарын авлага, тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа 15 байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг) мөн яамны үүдэнд байрлах дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр офицер, ахлагч, ажилтан алба хаагч, иргэд, олон нийтэд сурталчлан ажиллаж байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор Авлигын эсрэг хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг Соёмбо редакцын 7 хоног болгон эрхлэн гаргадаг сонинд нийтлүүлж, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний алба хаагчдад хүргэж ажиллалаа.



Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хүрээнд авлига, ашиг сонирхол түүний хор уршгийг таниулах, нийт бие бүрэлдэхүүний ёс зүй, зан харилцаа хандлагыг бэхжүүлэх зорилгоор их сургуулийн www.mndu.gov.mn сайтын хууль, эрх зүй буланд холбогдох хуулийн видео хичээл бэлтгэн оруулж, мэдээллээ шинэчлэн ажилласан.

Мөн тус их сургуулийн хүрээнд авлига, ашиг сонирхол түүний хор уршгийг таниулах, нийт бие бүрэлдэхүүний ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх зорилгоор их сургуулийн “ҮБХИС-Хууль эрх зүй”, “Эрдэм студи”, “ҮБХИС төгсөгчид”, “ҮБХИС Ёс зүйн дэд хороо” зэрэг цахим сайтуудаар “Авлигын эсрэг бид манлайлна”, “Бид авахгүй” аяныг жилийн хугацаанд өрнүүлэн, аяны хүрээнд соён гэгээрүүлэх болон нөлөөллийн 15 төрлийн видео бичлэг, контент, рийл, постер зэргийг хийж, нийтэд цахимаар хүргэн ажилласан.



Мөн “ҮБХИС-Хууль, эрх зүйн мэдээлэл” нэртэй Facebook групп нээн, 4.2 мянган гишүүнтэйгээр хууль, эрх зүйн мэдээллийг хүргэн ажиллуулж байгаа ба нийт 35 хуулийн /565 хуудас постер, слайд/, 29 эрх зүйн актын /212 слайд/ хичээл бэлтгэн нийтэлж, их сургуулийн нийт бие бүрэлдэхүүн болон олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх болон төрийн албан хаагчийн ёс зүйн соёлыг бэхжүүлэх зорилгоор видео, рийл, постер зэрэг нөлөөллийн компаниг ажлуудыг хийж нийтэд хүргэж хэвшээд

байна. Одоогоор нийт 511.8 мянган удаагийн хандалттай ажиллаж байна.

ГУРАВ. АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:



Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб нь Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль авлига, ашиг сонирхлын талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх,

албан тушаалын давуу байдал, авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, таслан зогсооход чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагчаас авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Батлан хамгаалах яам, харьяа байгууллага болон Зэвсэгт хүчний офицер, ахлагч, хугацаат болон цэргийн гэрээт албаны байлдагч, түрүүч, алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагын дарга нарт Авлигын тухай



ерөнхий ойлголт сэдвээр сургалт зохион байгуулах үүргийг 03/1576 дугаар албан бичгээр хүргүүлсэн.


Дээрх албан бичгийн хүрээнд дараах сэдвүүдээр яамны харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагууд сургалт зохион байгуулсан. Үүнд:

1. Авлигын тухай ойлголт, хор хөнөөл;
2. Авлигатай тэмцэх шалтгаан, арга зам;
3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаа дахь иргэдийн оролцоо;
4. Авлигын эсрэг хууль болон бусад хуулийн уялдаа холбоо, анхаарах асуудал.

Сургалтын хүрээнд давхардсан тоогоор нийт 2689 алба хаагч сургалтад хамруулсан.

Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан "Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалт" цахим сургалтад яамны харьяа байгууллага, нэгтгэл, анги байгууллагад шинээр томилогдон ажиллаж байгаа эрх бүхий албан тушаалтнууд хамрагдаж дараах сэдвийг судалсан. Үүнд:

1. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг;
2. Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, нэрсийн жагсаалт, мэдүүлгийн мэдээ, тайланг нэгтгэн гаргах тухай;
3. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем тус тус судалсан байна.



Алба хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Авлигын тухай ойлголт", "Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг", "Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээлэл", "Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм, анхаарах асуудал", "Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд", "Цэргийн албыг зохион байгуулах заавар", "Хүний эрх ба дүрмийн

бус харилцаа", "Хүний хувийн мэдээлэл хамгаалахад анхаарах асуудлууд", "Хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх", "Цахим орчны зохистой хэрэглээ", "Цахим орчин дахь хүүхэд хамгаалал ба ухаалаг утасны хэрэглээ", "Зам тээврийн осол, түүнээс урьдчилан сэргийлэх нь" "Авлигын мөн чанар, түүний шалтгаан хор хөнөөл" зэрэг сэдвүүдээр яамны харьяа байгууллагууд болон Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт 14 удаагийн 28 цагийн сургалтыг Төв аймгийн цагдаагийн газар, И-Монгол академи, Хүний эрхийн үндэсний комиссын аймаг, дүүрэг дэх референт, Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба, Үндэсний батлан хамгаалахын их сургууль болон хуулийн зөвлөхүүд тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 1830 хүнийг хамруулаад байна.

**ДӨРӨВ. АВЛИГА, АШИГ
СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСГЭХ
ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ
АРИЛГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар батлагдсан “Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд”, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журмыг Батлан хамгаалах яам, ЗХЖШ,

харьяа байгууллагууд төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, ангиуд батлан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус “Хөдөлмөрийн дотоод журам” болон худалдах, худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээнд авлигын эсрэг хэрэгжүүлэх үүрэгжүүлсэн эрх зүйн зохицуулалтуудыг тусган, байгууллагууд дотоод хэм хэмжээнд өөрчлөлт оруулан ажиллаж байна.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдал, гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн сургалтын хүрээнд давхардсан яам, харьяа байгууллага, Зэвсэгт хүчний хэмжээнд эрх бүхий албан тушаалтнуудыг Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсээс зохион байгуулсан сургалтад болон сургагч багш нарын тусламжтайгаар байгууллагууд дотооддоо зохион байгуулан явуулж, нийт 500 гаруй алба хаагч сургалтад хамрагдсан байна.

Батлан хамгаалах яам, харьяа аж, ахуйн нэгж, байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хуурай замын цэргийн командлал, Агаарын цэргийн командлал, Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, харьяа нэгтгэл, анги, байгууллагаас Шилэн дансны тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллээс Төрийн болон албаны нууцын тухай хууль болон холбогдох дүрэм, журамд хамаарахаас бусад мэдээллийг www.tender.gov.mn цахим хуудаст тухай бүр байршуулан ажилласан.

Батлан хамгаалах яамнаас 2025 оны байдлаар 8 тендерийн, иргэд аж ахуйн нэгжтэй байгуулсан 28 төрлийн гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаарх нэмэлт заалт тусган, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Үүнд:

10. Авлига, ашиг сонирхол

10.1. Талууд авлигын эсрэг хууль болон нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хувийн ашиг сонирхлоос ангид, тэгш шударгаар хэрэгжүүлж оролцоно.

10.2. Талууд авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн гэж үзвэл үндэслэл бүхий гомдлоо холбогдох албан тушаалтан, байгууллагад гаргана.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулах бүр төрлийн гэрээнд ЭБАТ-ний эрх хэмжээний хүрээнд хяналт тавьж гарын үсэг зуран баталгаажуулдаг, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтуудыг тусган хяналт тавин ажиллаж байна.

Батлан хамгаалах салбарын хэмжээнд иргэд, алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн 2024 оны тайланг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, тайланг Батлан хамгаалахын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 1а/23 дугаар албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн.

Батлан хамгаалах салбарын хэмжээнд иргэд, алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн 2025 оны I улирлын тайланг нэгтгэн Батлан хамгаалахын сайдын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 1а/864 дугаар албан бичгээр, мөн 2025 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 1а/2306 дугаар албан бичгээр, 2025 оны III улирлын тайланг яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 1в/3656 дугаар албан бичгээр тус тус Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны даргын үүрэг гүйцэтгэгчид, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тус тус хүргүүлсэн.

Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар иргэд, алба хаагчдаас 7393 өргөдөл, гомдол ирснээс 7009 өргөдөлд хариу өгч, шийдвэрлэж, хэрэгжилт 95,9 хувьтай байна.

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байгаа 384 өргөдөл байгаа болно. (Үүнээс Батлан хамгаалах яаманд 72, ЗХЖШ болон харьяа командлал, газар, нэгтгэл, анги, байгууллагад 269, яамны харьяа байгууллагад 43 өргөдөл, гомдол байна.)



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.8-т заасны дагуу Батлан хамгаалах салбарын 2024 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ 2025 оны I улирал, хагас жил, III улирлын тайлан, мэдээг яамны цахим хуудсанд байршуулсан.

Батлан хамгаалах салбарын 2025 оны өргөдөл, гомдлын тайланг Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын 1-д заасан хугацаанд буюу 2026 оны 01 дүгээр сарын 10-ны дотор Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

Албан хаагчид, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг нийт 5 сувгаар (биечлэн, утсаар, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах "11-11" төвөөс хуваарилагдаж ирсэн, шуудангаар, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын цахим хуудас, олон нийтийн сүлжээ, албаны цахим хаягаар) хүлээн авч, бүртгэл хөтлөлтийг хийн, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулан шийдвэрлүүлж, хариуг хүргүүлэн ажилласан.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Батлан хамгаалах яамны 2025 оны
1.2 дугаар сарын 14-ны өдрийн

16/47/24 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт

**БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРААС 2025 ОНД АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

**2. ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛИЙГ ХҮЛЭЭСЭН АВЛИГААС АНГИД НИЙТИЙН
АЛБЫГ БЭХЖҮҮЛНЭ.**

*2.5. Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн
мэдэх эрхийг баталгаатай эдлүүлнэ.*

2.5.2. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр
цахим системд нээлттэй байршуулж, хуулийн хэрэгжилтэд хоёр жил тутам үнэлгээ
хийж олон нийтэд ил тод мэдээлнэ.

Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын
ангиллаар Шилэн дансны цахим системд сар, улирал бүрээр төсвийн шууд захирагч
нар болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд мэдээллийг нийтэлж
хэвшсэн.

Мөн ЗХЖШ болон яамны харьяа байгууллагуудын цахим хуудасны мэдээлэл,
шилэн дансанд байршуулсан мэдээллийг тухай бүр нь нягтлан шалгаж,
хэрэгжилтийг ханган ажиллах тал дээр хамтран ажилласан. Үндэсний батлан
хамгаалахын их сургууль нь төрийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод
болгохоор заасан байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион
байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа болон үзүүлж
байгаа үйлчилгээний талаарх мэдээллийг их сургуулийн цахим сайтад
<http://mndu.gov.mn> байршуулан, хэрэгжилтэд хоёр жил тутам үнэлгээ хийж олон
нийтэд ил тод мэдээлж байна.

Батлан хамгаалах яам, харьяа байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй
байлгах, үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор хуулиар
хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй
байршуулан ажлын байрны сул орон тоог байгууллагын цахим хаягт байршуулан,
сонгон шалгаруулалтыг зохион байгуулан ажилласан байна.

Мөн Монгол улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан
“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг
тогтоох тухай журам”-ыг мөрдлөг болгон салбарын онцлог байдлыг харгалзан зарим
оруулах мэдээллийг хуулийн хугацаанд оруулан, сар бүр оруулах мэдээллийг дараа
сарын 08-ны өдөр, тухай бүр оруулах мэдээллийг цаг хугацаанд нь хугацаа
хоцроолгүй тайлагнасан.

*2.6. Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга
хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ.*

2.6.2. Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө
боловсруулж хэрэгжүүлж хэвшүүлнэ.

Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд яамны 2025 оны Эрсдэлд суурилсан авлигын эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, яамны удирдлага, бие бүрэлдэхүүнд авлигын эсрэг нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун, соёлыг төлөвшүүлэх зорилго тавьж, нийт бие бүрэлдэхүүний авлига, ашиг сонирхлын талаарх хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, нөлөөллийн компанит ажил, арга хэмжээ зохион байгуулах, авлига, ашиг сонирхол гарч болох шалтгаан, нөхцөлийг судлан, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах гэх 3 зорилтын хүрээнд 13 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Мөн “Эс Ай Си Эй” ХХК-ийн судалгааны баг “Авлигатай тэмцэх газар”-ын захиалгаар хийгдсэн Шударга байдлын үнэлгээнд Батлан хамгаалах яам, Үндэсний батлан хамгаалах их сургууль, Цэргийн төв эмнэлэг, Батлан хамгаалахын төв архивын ажилтан албан хаагч, иргэдийг хамруулж судалгааг хугацаанд нь хүргүүлсэн.

6. АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖИЙГ ХИЙДЭЛГҮЙ ТОДОРХОЙЛОХ, ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО.

6.4. Шаардлагатай бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.

6.4.11. Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулна.

Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб болон харьяа байгууллагууд 2025 оны эрсдэлд суурилсан Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, бие бүрэлдэхүүнд авлигын эсрэг нийгмийн хор уршгийг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун, соёлыг төлөвшүүлэх талаар төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уг төлөвлөгөөг ЗХЖШ болон яамны харьяа 15 байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах талаар үүрэг, чиглэл өгсөн.

Батлан хамгаалах салбарын бие бүрэлдэхүүнийг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, урьдчилан сэргийлэх, авлига үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгах, эрсдэлийг бууруулах, Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх, энэ чиглэлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилго дэвшүүлэн 3 зорилт бүхий 13 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

Алба хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Авлигын тухай ойлголт”, “Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг”, “Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээлэл”, “Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм, анхаарах асуудал”, “Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд”, “Цэргийн албыг зохион байгуулах заавар”, “Хүний эрх ба дүрмийн бус харилцаа”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалахад анхаарах асуудлууд”, “Хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх”, “Цахим орчны зохистой хэрэглээ”, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал ба ухаалаг утасны хэрэглээ”, “Зам тээврийн

осол, түүнээс урьдчилан сэргийлэх нь” “Авлигын мөн чанар, түүний шалтгаан хор хөнөөл” зэрэг сэдвүүдээр Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт 14 удаагийн 28 цагийн сургалтыг Төв аймгийн цагдаагийн газар, И-Монгол академи, Хүний эрхийн үндэсний комиссын аймаг, дүүрэг дэх референт, Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба, Үндэсний батлан хамгаалахын их сургууль болон хуулийн зөвлөхүүд тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 500 гаруй хүнийг хамруулсан.

7. ТӨСӨВ, САНХҮҮ, АУДИТЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАН, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АВЛИГЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛНА.

7.1. Төсвийн төлөвлөлтийн тогтолцоог урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулж, тэгш хүртээмжтэй, нээлттэй, олон нийтийн оролцоог хангах замаар бэхжүүлнэ.

7.1.2. Төсвийн тухай хуульд төсвийн орлого, зарлагын мэдээллийг төсөв захирагчдаар нийтлэхээс гадна эдийн засгийн болон зориулалтын ангиллаар тооцон тусгана.

Батлан хамгаалах яам, харьяа байгууллага, ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, салбарын хэмжээнд төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар Шилэн дансны цахим системд сар, улирал бүрээр төсвийн шууд захирагч нар болон төсвийн ерөнхийлөн захирагчийн хэмжээнд мэдээллийг нийтэлж хэвшсэн.

9. СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАН ЦОГЦ БАЙДЛААР ЗОХИОН БАЙГУУЛНА.

9.5. Төрийн албанд ёс зүйн шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж ажилд авах соёлыг төлөвшүүлж, тогтолцоог бүрдүүлнэ.

9.5.2. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.

Батлан хамгаалах яамны харьяа байгууллагуудын иргэд, олон нийтэд үзүүлэх үйлчилгээг нээлттэй түргэн шуурхай, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар зөвлөмж, мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Батлан хамгаалах яамнаас бэлтгэсэн “Авлигын эсрэг нэгдье” шторкийг Батлан хамгаалах яам, Соёмбо редакц, АТГ-ыг Олон нийтийн төвийн цахим хуудас, харьяа 15 байгууллагын цахим хуудсанд байршуулж, ажиллах үүрэг чиглэлийг өгч байгууллагууд өөрийн цахим хуудаст байршуулан сурталчилсан бөгөөд 278 лайк, 278 шэйр авсан хандалттай байгаа бөгөөд яамны 1800-1144 дугаарын утсаар Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаатай холбоотой гомдол, саналыг хүлээн авч тухай бүрд нь шийдвэрлэн ажиллаж байна.

Мөн Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн “Эрдэм студи”-ээр “Авлигын эсрэг бид манлайлна” сэдэвт видео рийл, постер хийж нийтэд хүргэж байна.

“ҮБХИС-Хууль, эрх зүйн мэдээлэл” нэртэй Facebook групп нээн, 4.2 мянган гишүүнтэйгээр хууль, эрх зүйн мэдээллийг хүргэн ажиллуулж байгаа ба нийт 35 хуулийн /565 хуудас постер, слайд/, 29 эрх зүйн актын /212 слайд/ хичээл бэлтгэн

нийтэлж, их сургуулийн нийт бие бүрэлдэхүүн болон олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, болон төрийн албан хаагчийн ёс зүйн соёлыг бэхжүүлэх зорилгоор видео, рийл, постер зэрэг нөлөөллийн компанит ажлуудыг хийж нийтэд хүргэж байна. Одоогоор нийт 412.9 мянган удаагийн хандалттай байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний офицер, ахлагч, хугацаат болон цэргийн гэрээт албаны байлдагч, түрүүч, алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагын дарга нарт Авлигын тухай ерөнхий ойлголт сэдвээр сургалт зохион байгуулах үүргийг 02/1576 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдал, гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль сургалтын хүрээнд давхардсан тоогоор нийт 2198 алба хаагч сургалтад хамрагдсан байна.

10. ГАМШГААС ХАМГААЛАХ, ОНЦ БАЙДЛЫН ҮЕИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУСГАЙЛСАН ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛНЭ.

10.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, дотоод хяналтыг сайжруулах тусгайлсан бодлого, хөтөлбөр, тогтолцоог бий болгоно.

10.1.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа болон хуулиар төрийн нууцад хамааруулснаас бусад мэдээллийг ил тод болгож, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

Батлан хамгаалах яам болон харьяа байгууллагууд Монгол Улсын “Шилэн дансны тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заагдсан арга хэмжээний биелэлтийг байгууллагын шилэн дансны хуудсанд тухай бүр, сар, улирлын мэдээг оруулж, баталгаажуулах ажилд сар бүр хяналт тавьж ажилласан бөгөөд төрийн нууцад хамаарах мэдээллийг оруулаагүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай бараа, ажил үйлчилгээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох [/https://www.tender.gov.mn/mn](https://www.tender.gov.mn/mn) байгууллагын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендер шалгаруулалтын үр дүнг цахим системийн хуудсанд нээлттэй байршуулж ажилласан.

Мөн Батлан хамгаалах яам болон харьяа Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, зарлагын гүйлгээ бүр, холбогдох

шийдвэрийн талаарх мэдээ, мэдээллийг шилэн дансанд хугацаанд нь бүрэн байршуулсан.

Байгууллага бүр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээнүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх, тэдгээрийн талаар мэдээлэх, хяналт тавих талаар тусгаж ажилласан.

10.2. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хариу арга хэмжээний санхүүжилт, хандив, тусламжийн үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох бодлогын баримт бичгийг боловсруулж, гүйцэтгэлийн мөрөөр авч хэрэгжүүлэх хяналт, хариуцлагыг нэмэгдүүлнэ.

10.2.2. Стратегийн нөөц, батлан хамгаалах материаллаг нөөцөөс бусад нөөцийн худалдан авалт, зарцуулалтыг нууцаас гаргах, ил тод болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Батлан хамгаалах салбарын хэмжээнд 2025 онд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй тендер шалгаруулах аргаар 19 тендерийн 154 багц 50,721.57 сая төгрөг, харьцуулалтын аргаар 4 тендерийн 4 багц 152,1 сая төгрөг, нэг эх үүсвэрээс худалдан авах харгаар 1,300.7 сая төгрөг, шууд худалдан авах аргаар 1,700.0 сая төгрөг нийт 53,721.57 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулж, тендерт шалгарсан байгууллагуудтай 48,207.44 сая төгрөгийн гэрээ байгуулан ажилласан.

Стратегийн нөөц, батлан хамгаалах материаллаг нөөцөөс бусад нөөцийг Зэвсэгт хүчний төвлөрсөн хангалтаар худалдан авсан материал хэрэгслээр Дайчилгааны нөөцийн хүнс хуурай хэрэглэлийг 70 хувь, шатахуун тосолгооны материалыг 100 хувь сольж шинэчлээд байна.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ